

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ХЭЛТЭС,  
АГЕНТЛАГИЙН ДАРГА НАРЫН ХУРЛЫН  
ТЭМДЭГЛЭЛ**

2021 оны 03 дугаар сарын 26

№ 01

Дархан

Хурал 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 14:10 цагт аймгийн ЗДТГ-ын хурлын танхимд эхлэв. Хуралд аймгийн Засаг дарга Б.Азжаргал, аймгийн Засаг даргын нэгдүгээр орлогч А.Түвшинбат, аймгийн Засаг даргын орлогч Б.Жавхлан, Хотын захирагчийн орлогч Б.Батболд, аймгийн ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Хүрэлчулуун, аймгийн ЗДТГ-ын хэлтсийн дарга нар, Боловсрол, соёл урлагийн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Онцгой байдлын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Цагдаагийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Мэргэжлийн хяналтын газар, Орон нутгийн өмчийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Эрүүл мэндийн газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэс, Захирагчийн ажлын алба, Нийтийн аж ахуйн үйлчилгээний газар оролцов. Дархан орон нутгийн зам тээвэр ОНӨААТҮГ, Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар ОНӨААТҮГ, Дархан дахин төлөвлөлт ААТҮГ, Мэдээлэл технологийн алба ОНӨААТҮГ-ын дарга нар оролцов.

**Б.Азжаргал /Аймгийн Засаг дарга/-ын өгсөн нийтэд хамааралтай үүрэг даалгавар:**

- Хурал дээр гар утсаар оролдохгүй байх. Гар утасныхаа сүлжээ болон дууг хааж орж байхыг хатуу анхааруулъя.

- Э.Равжаадэлгэрэх даргад хариуцлага тооцно. Хуралд байнга хоцорч ирдэг.

- Миний тавьж байгаа хамгийн эхний шаардлага бол ямар ч хурал цагтаа эхэлнэ. Хурал удирдах хүн ирээгүй байсан ч цагтаа хэн нэг нь удирдаад цагтаа эхэлж байна. Хурал эхэлснээс хойш орж ирэхийг зөвшөөрөхгүй. Аливаа хурал зөвлөгөөн нэг цаг гучин минутаас хэтрэхгүй байна. Дуудсан цагт ажил хариуцсан дарга нар цаг хугацаандаа ирнэ. Хурлыг хугацаанд нь хийгээд цэгцтэй оновчтой, нийтэд хамааралтай асуудлуудаа хэлэлцээд явна.

- Цаашдаа хэлтэс, агентлагийн дарга нарын хурлыг хэсэгчилсэн байдлаар зохион байгуулж байх хэрэгтэй. Аймгийн Засаг даргын нэгдүгээр орлогч А.Түвшинбат нийгмийн асуудлын хэлтэс, агентлагуудаа удирдаж хурлыг зохион байгуулж явна. Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын асуудлуудаа аймгийн төсөв санхүү, төсөл хөтөлбөр, үйлдвэрлэл, байгаль орчны бодлогын асуудал хариуцсан орлогч Б.Жавхлан, дэд бүтцийн байгууллагын хурал зөвлөгөөнөө Хотын захирагчийн орлогч Б.Батболд удирдаад явна. Хэсэг хэсгээрээ хуралдаад тулгамдаж буй асуудлуудаа нэгдсэн байдлаар хэлэлцэж байна.

- Хийж байгаа ажилдаа эзэн болж байх.

- Дархан хотын байгуулагдсаны 60 жилийн ой энэ жил тохиож байна. Тиймээс өөрийн байгууллагын гадна тохижилт, нүүр царайндаа анхаарах нь зүйтэй.

- Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга Д.Жаргалсайхан “Төрийн байгууллагын стандарт” гэдэг зүйлийг судалж төрийн байгууллагуудад хэрэгжүүлэх ажлыг зохион байгуул. Зарим байгууллага руу орохоор ханан дээр нь уул усны зураг өлгөсөн байгаа нь зохимжгүй байна. Үүний оронд Дархан хотын зураг эсхүл төрийн сүлд байршуулах байдлаар шийдвэрлэ. Төрийн байгууллагууд нэг стандартыг мөрдөж ажиллана.

- Байгууллагын хаягжилтын асуудал маш чухал. Уйгаржин монгол бичгээр гаднах хаягаа бичиж болж байна. Байгууллага бүр өөрсдийн байрны тохижилтыг хар. Дархан хотын 60 жилийн ойд зориулан байгууллагынхаа гадна талбайг яаж тохижуулснаа тайлагнах.

- Мөн ажилчдын дүрэмт хувцастай холбоотой асуудал байна. Мэргэжлийн байгууллагууд бол нэгдсэн дүрэмт хувцастай. Бусад байгууллагууд хэрхэх вэ гэдгийг судлан танилцуулах.

- Төрийн байгууллагын цахим шилжилттэй холбоотой асуудал байна. Байгууллага бүр өөр өөрсдийнхөө чиглэлээр цахим шилжилтийг олж аваад хэрэгжүүл. Ялангуяа энэ цар тахалтай төрийн байгууллагуудын үйл ажиллагааг хязгаарласан үед заавал гараас гарт дамжуулж үйлчилгээ үзүүлэх үү? Энэ асуудлыг зохион байгуулах.

- Ажилтнуудын нийгмийн асуудал маш чухал. Нэг ажилтныхаа ч гэсэн нийгмийн асуудлыг шийдэх хүрээнд байгууллага дотроо зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилла. Сардаа эсхүл улиралдаа нэг ажилтныхаа амьдралын орчныг сайжруул. Хамтраад хийж болох зүйл. Бага хүүтэй орон сууцны зээлээр хангах төрийн албан хаагчийн орон сууцны бодлогыг хэрэгжүүл. Энэ тал дээр аймаг орон нутаг бүх талаар нь дэмжиж ажиллана. Дэд бүтэцтэй газрын асуудлыг нь эхлээд шийдэж болно. Энэ боломжийг судал. Ажилтан албан хаагчид ажлын байран дээрээ хэрхэн байх вэ гэдэг тал дээр бас анхаарах хэрэгтэй.

- Ажилчид ажлын байранд дээр хэрхэн ажиллах, ёс зүйтэй байх асуудалд анхаарах, ажлын байранд архи согтууруулах ундаа хэрэглэх асуудал хаа ч байж болохгүй. Тэр дундаа боловсролын байгууллага буюу сургууль, цэцэрлэгүүдэд. С.Галбадрах дарга 9 дүгээр сургууль дээр ямар зүйл болсон, тэр холбогдох арга хэмжээг нь ав. Ийм зөрчил гаргасан үйлдлийг хэрхэвч хүлээн зөвшөөрөхгүй, авах ёстой арга хэмжээг тухай бүрд нь авч ажиллах болно гэдгийг мэдэгдье.

- Байгууллагын удирдлагуудад ширээний таван ном гэдэг хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Үүнийг О.Хүрэлчулуун, С.Галбадрах дарга 2 анхааралдаа авч, хэрэгжүүл, энэ нь зүгээр 5 ном уншаад өнгөрөх биш, хувь хүний менежментдээ өөрчлөлт гаргана. Үйл ажиллагаандаа шинэ санаа санаачлагыг хэрэгжүүлэх нь чухал. Сая та бүхэнд ажлын байранд мөрдөж ажиллах үндсэн чиглэлүүдийг танилцууллаа. Төрийн байгууллага, албан хаагчдад дөрвөн зарчмыг баримталж ажиллана. Үүнд:

### **1. Авлига, ашиг сонирхлоос ангид байх зарчим:**

Байгууллага бүр байгууллагынхаа эрхэм зорилгыг ил тод байршуулах.

Авлига ашиг сонирхол, хүнд суртлаас ангид байх. /Татвар, газар, иргэний бүртгэл, худалдан авах ажиллагаа гэх мэт/ Дархан-Уул аймаг улсын хэмжээнд жишиг авилга ашиг сонирхолгүй аймаг болох зорилт тавина. Төрийн албыг хашиж байгаа хугацаанд ашиг сонирхлоос ангид байх ёстой. Ялангуяа авлига гэдэг зүйл аль ч төрийн байгууллагад гарах ёсгүй. Миний бие энэ албан тушаалд байх хугацаанд худалдан авах ажиллагаатай холбоотой ямар ч асуудалд оролцохгүй. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлыг ил тод, хардалтгүй болгох тал дээр анхаарлаа хандуулж ажил, Худалдан авах ажиллагаа зохион байгуулдаг 5 хүний бүрэлдэхүүнийг сонгодог механизмыг өөрчлөх саналаа холбогдох дээд байгууллагад нь хүргүүл. Авлига ашиг сонирхлоос ангид байх тал дээр бүгдээрээ манлайлж ажиллая. Иргэдийн хардаад байгаа зүйлийг ил тод болго. Энэ зүйлийг байгууллагынхаа уриа болгож ажиллацгаа. Энэ худалдан авах ажиллагаа, тендертэй холбоотой асуудлыг Б.Баасанжаргал дарга гардаж зохион байгуулна, шүүмжлэл дагуулдаг тендер, худалдан авах ажиллагааг цэгцэлнэ.

### **2. Зарчимч, ёс зүйтэй, эерэг харилцаа, хандлагыг ажлын байран дээр мөрдөх:**

Ёс зүйтэй ажиллана гэдэг маш том асуудал, нэг ч гэсэн иргэний асуудлыг нааштай шийдэхийн төлөө төрийн албан хаагч ажиллана, энэ асуудал нь болохгүй байна гээд иргэний өөдөөс хууль яриад суухын оронд нааштайгаар шийдэхийн төлөө хүнлэг, ёс зүйтэй ажиллах нь чухал, үүнд анхаарч ажиллах. Төрийн албан хаагчийн харилцаа, хандлага дээр анхаарах, байгууллагадаа нэвтрүүлэх шаардлагатай. /Төрийн байгууллага бол үйлчилгээний байгууллага. Иргэд хаадын хаан байх ёстой, төрийн албан хаагч бүр үүнийг анхаарч, харилцаа, хандлагаа сайжруулах/

### **3. Бүтээлч сэтгэхүйтэй байх зарчим:**

Төрийн байгууллагууд хуулиар олгогдсон хийдэг ажлаасаа гадна бүтээлч ажлыг санаачилж хийдэг байна, О.Хүрэлчулуун дарга санаачлаад төрийн байгууллагууд сар болгон нэг бүтээлч ажлуудыг санаачилж хийдэг байх талаар бүх шатны төрийн байгууллагуудад чиглэл өгч, хэрэгжилтийг хангуул, хэвшил болго.

### **4. Бусдаас суралцах зарчим:**

Бусдаас суралцахаас хэзээ ч битгий ич. Улсын хэмжээнд яг таны салбарт бусдаас илүү хэрэгжүүлсэн салбар байх ёсгүй. Эрдэнэтийн Нийгмийн даатгалын хэлтэс хэрхэн ажиллаж байна, туршлага суралц. 21 аймаг, 9 дүүргээс таны салбарт хэрхэн тэргүүлж ажиллаж байгаа туршлагаас суралцаж, өөрийн ажилд нэвтрүүлэх, үүнийг хатуу анхаарах хэрэгтэй байна. Үүнийг Нийгмийн даатгалын хэлтсээс эхлэн хэрэгжүүлж эхэл. Чадахгүй бол өөрөө өргөдлөө өгөөд гарах ёстой. Дархан сум, Нийтийн аж ахуй ч мөн анхаарч бусад аймаг хогоо хэрхэн цэгцтэй ангилан ялгаж байна, түүнийг судал, бусад аймагт гайхшруулаад байгаа туршлагыг даруй судалж нэвтрүүлэ. Байгууллагуудад дараах үүрэг чиглэлийг өгч байна. Үүнд:

#### **1. Улсын бүртгэлийн хэлтэст:**

- иргэдэд үзүүлдэг үйлчилгээнүүдээ цахимжуулах, сунгалт болон хөрөнгийн үйл ажиллагаанд хэрэгжүүлж буй яаралтай болон энгийн гэх үйлчилгээний ангиллыг болиулах
- хүнд суртал, авлига ашиг сонирхлоос ангид байх, аймгуудаас туршлага судалж нэвтрүүл, өөр аймагруу томилолтоор явах, туршлага судлах боломжийг О.Хүрэлчулуун дарга агентлагийн дарга нарт олго, Улсын бүртгэлийн хэлтэс дээр хүнд суртал, авлига, ашиг сонирхлын асуудал удаа дараа яригддаг, иргэдээс санал гомдол их ирдэг, энэ асуудлыг М.Хувьзаяа дарга анхаар, албан хаагчдын харилцаа, хандлага дээр анхаарч, өөрчлөлт хий, дээрх асуудлыг таслан зогсоо.

#### **2. Захирагчийн ажлын албанд:**

- жилийн дотор орон сууцны дээврийн засварын ажилтай холбоотой асуудлыг шийдэх,
- орон сууцны хороололд байгаа шоргоолж устгалыг бүрэн хийх, ямар боломж байна, үүнийг судал, 2021 оны 07 сарын 01 гэхэд шоргоолж устгалын асуудлыг шийдэж дуусгах, шоргоолж бүрэн устсан байх.
- ногоон байгууламжийн шарилж устгалыг бүрэн хийх, дөрвөн жилийн хугацаанд хэрхэн шийдэх гарцыг судал, “Шарилжгүй Дархан” хөтөлбөр өнгөрсөн дөрвөн жилд хэрхэн үр дүнтэй хэрэгжсэн. Шарилж устгалын асуудлыг нэг жилийн хугацаанд шийдсэн байх.
- хот дотор мал оруулахгүй байх, малтай өрхийг хотын төвөөс гаргах, энэ асуудлыг мөн нэг жилийн дотор цэгцэл. Дархан сум хариуцаж, шийднэ. Тулгаа дарга анхааралдаа ав, малтай айл хотын төвд байх ёсгүй, хатуу анхаараарай.

#### **3. Дархан дахин төлөвлөлт ОНӨААТҮГ, НААҮГазарт:**

- Нарантолгой дахин төлөвлөлт хийх нүүрний эгнээний 180 айлыг дулааны шугамд холбох, дэд бүтцийг шийдэх, гэрэлтүүлэг хийх, хогийг нэгдсэн журмаар авдаг болох асуудлыг энэ жил шийднэ, наадмын үеэр 980 гэрэлтүүлгийн ажлыг шийд, гэр хорооллын бүх гудамжны гэрэлтүүлгийг шийд.
- барилга байгууламж барих гэж буй барилгын хашааг цэгцлэх, Паркийн хажуугийн хашаа зэрэг, энэ хашааны асуудлыг цэгцэл.
- Бараат хогийн цэгийг устгах,
- сууц өмчлөгчдийн холбоог орон сууцны контор руу шилжүүлэх,
- нохой муур устгалыг эрчимтэй зохион байгуулах,

#### **4. Дархан орон нутгийн зам тээвэр ОНӨААТҮГазарт:**

- Дархан хотын доторх замын нөхөөс хийх ажлыг чанартай үр дүнтэй хийх,
  - нийтийн тээврийн зохицуулалт хийх, шинэлэг үйлчилгээ нэвтрүүлэх, нийтийн тээврийн соёл Дарханд байна уу, дуудлагын такси үйлчилгээг нэвтрүүлж болох уу, таксны асуудал хүнд байна, үүнд хяналт тавь.
5. Нийгмийн даатгалын хэлтэст:
- үйл ажиллагаагаа сайжруулан цахим хэлбэрт шилжүүлэх, зургаан сарын хугацаатай үүрэг өгч байна. Энэ хугацаанд Орхон аймгийн нийгмийн даатгал шиг үйлчилгээ үзүүлдэг болсон байх, 2021 оны 09 сарын 01 хүртэл хугацаа байна.
6. Байгаль орчин, аялал жуулчлалын газарт:
- шинээр ашигт малтмал олборлох зөвшөөрлийг зогсоох, төрийн байгууллагын дарга нар алттай холбоотой асуудалд оролцохгүй байх,
  - “Ногоон Дархан” хөтөлбөрийг 2021 оны 05 дугаар сарын 01 гэхэд хэрэгжүүлж эхэлсэн байх,
  - “Ган хүдэр” ХХК, Шохойн байгууламжийн агаар орчныг бохирдуулж байгаа асуудлыг 2021 оны 10 дугаар сарын 01 гэхэд шийдвэрлэсэн байх, Дарханчуудыг утаагаар хордуулмааргүй байна. Үүнийг шийдэж танилцуул.
  - Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор түүхий нүүрсний хэрэглээг 2023.05.01-ээс өмнө таслан зогсоож, шахмал түлшний үйлдвэр барих асуудлыг шийдвэрлэнэ. Газрын асуудлыг шийдэж, гурван жилийн хугацаанд үйлдвэр барих асуудлыг шийд.
7. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт:
- Өсвөр үе, хүүхэд багачуудын дунд нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулагдахгүй байна, 3 үеийн хэлхээнд үндэслэн бодитой арга хэмжээнүүдийг хийж хэрэгжүүлмээр байна. Хүүхдийн зуслангийн үйл ажиллагааг сайжруулах, хүүхэд багачууд сайхан орчинд амрах боломжийг бий болго, 2021 оны 05 дугаар сарын 01 гэхэд зуслангийн 2 байрыг шинэчлэн засварлаж дуусга, 60 жилийн ойгоор зуслангийн барилгын асуудлыг шийдэж, хүүхдүүд амрах боломжийг бүрдүүл, орчны тохижилтыг хийж, 60 жилийн ойгоор зусланд хүүхдүүд амардаг болсон байна.
8. Нийтийн аж ахуйн үйлчилгээний газарт:
- ажилчдын ажиллах нөхцөл орчинг сайжруулах, техник хангамжийг сайжруулах, СӨХ хариуцлагатай ажлаа хийх шаардлагатай байна, нийтийн аж ахуйн үйлчилгээний албан хаагчид хогийг нь ачиж, байрны гадна дотно талбай, орцыг цэвэрлээд байхад СӨХ нь ажлаа хийхгүй байна. НААҮГ-ын техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх, нэмэгдүүлэх шаардлагатай, албан хаагчдын хувцасны асуудлыг шийдэж, 2 ээлжийн хувцастай болгох, үүнийг яаралтай шийдвэрлэ. /2-оос доошгүй техникийн шинэлчлэл хийх/
  - хогны хураамжийн системийг өөрчлөх, хог татан авах ажлыг сайжруулах,
  - цас орсонтой холбогдуулан давс цацах нөөц дууссан байсан, ийм асуудлыг дахин гаргахгүй байх, төсөвт тусган нөөцийг бүрдүүлдэг байх,
9. Боловсрол, соёл урлагийн газарт:
- тухайн салбарт ажиллаж байгаа албан хаагчдын мэдлэг ур чадвар, ёс зүйг дээшлүүлэх ажил зохион байгуулах,
  - “Багш-Манлайлал” хөтөлбөр хэрэгжүүлж, багш сурагчиддаа өөрөө манлайлж, үлгэрлэдэг болгох, үүнийг Галбадрах дарга санаачлан, үр дүнтэй ажлыг зохион байгуул,
  - багш ажилчдыг чадавхжуулах, дахин сургах төлөвшүүлэх, атестатчлах нь зүйтэй.
  - Мэргэжлийн хүмүүсийн үг хэл яриа, онолыг бодит түвшинд нэвтрүүлэх, ахмад үеэс туршлага судлах, хойш үедээ өвлүүлэх,
10. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт:

- Хот төлөвлөлтийнхөө дагуу газар зохион байгуулалтын ажлаа явуулах, Дархан суманд иргэдэд газар өмчлүүлэхгүй байх, томоохон үйлдвэр шинээр барих хүсэлтэй иргэн, аж ахуй нэгж байгууллагад газрын асуудлыг шийдвэрлэж өгөх, боломжийг судлах, ажлын байр нэмэгдүүлэн бизнес хийх хүсэлтэй хүмүүсийг дэмжиж ажиллана, төлөвлөлтийн дагуу газрын асуудлыг шийдвэрлэж өгөх нь зүйтэй.
- 0.7 га газар хүссэн иргэдэд Орхон, Хонгор суманд газар өмчлүүлэх талаар судлан танилцуул. Хонгор сумын иргэд Зулзагын голоос газар хүссэн, үүнийг судлан шийдвэрлэж, олгох боломжтой бол олгож, асуудлыг шийд, боломжгүй бол иргэдэд боломжгүй гэдэг хариуг өг, битгий чирэгдэл учруулаад бай.

#### 11. Мэргэжлийн хяналтын газарт:

- мэргэжлийн зөвлөгөө өгдөг байгууллага болох,
- үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж буй иргэн, аж ахуй нэгж байгууллагад үзүүлэх дарамт, шахалтыг багасгах, зах орчмын нүхэн гарцны хажууд түр хугацаагаар зөвшөөрөл олгож, ажлын байр бий болгож, иргэдэд үйлчилгээ үзүүлэх боломжийг судлан, иргэд ажлын байраар хангагдах орчин нөхцөлийг судал, хатуу дүрэм журмыг мөрдөх бол ажлын байр нэмэгдэхгүй, аль болох уян хатан хандах нь зүйтэй, 4 жилийн хугацаанд Дархан-Уул аймагт нэг ч гэсэн ажлын байр нэмэгдсэн байх ёстой. Энэ маш чухал үзүүлэлт, МХГ-аас гаргаж байгаа дүрэм, журам ажлын байрыг дэмжсэн байх ёстой. Хуулиар хориглосон зөрчилтэй байдлыг мэдээж таслан зогсоох нь зүйтэй.
- байцаагчдын харилцаа хандлагад анхаарах. Гол нь ажлын байр хадгалагдсан, нэмэгдсэн байх нь эцсийн үр дүн.

#### 12. Дархан сумын Засаг даргад:

- Цар тахалтай хүнд цаг үед эдийн засгийг сэргээх, иргэдийн ажлын байрыг хадгалах зорилгоор сум хөгжүүлэх сангийн зээлийг нэг иргэн, аж ахуй нэгжид 5.0 сая хүртэлх төгрөгийг төсөл хүлээж авахгүйгээр шууд олгох асуудлыг судлан шийдвэрлэх,
- Зуны улиралд биржийн явган хүний гарц болон түүний ойролцоо түр ажлын байр гаргах гудамж талбайг нэмэгдүүлэх ажлыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газартай хамтран судлан танилцуулах,

Та бүхэнд чиглэл чиглэлийн хүрээнд дээрх үүрэг даалгавруудыг өглөө. Дархан хотын хөгжил дөрвөн жилийн хугацаанд дэвших үү буурах уу гэдэг нь та бүхний хийж хэрэгжүүлсэн ажил, шийдвэрүүдээс шууд шалтгаална. Бүгд биелүүлж чадах эсэхээ батлах уу, чадах уу, үүрэгт ажилдаа эзэн болж чадахгүй бол чаддаг хүнд нь ажлаа өгөх хэрэгтэй. Миний өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хэрэгжүүлж байж бид цаашдаа хамтарч ажиллана. Та бүхэнд ажлын амжилт хүсье.

Хурал 15:10 цагт дуусав.

### **ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС**